



Australian Government
**Department of Immigration
and Border Protection**

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ АВСТРАЛИ УЛСЫН ВИЗНИЙ МЭДҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВАХ ТӨВ (AVAC)

Монгол Улсад амьдарч буй иргэд Австрали Улсад зорчих визний материалыг өөрийн биеэр Улаанбаатар хот дахь Австрали Улсын визний мэдүүлэг хүлээн авах төв (AVAC)-д өгнө. Мөн Монгол Улсад амьдарч буй иргэд өв залгамжлан Австрали Улсын иргэншил хүсэх мэдүүлгээ AVAC төвд өгөх боломжтой.

Австрали Улсын Цагаачлалын алба VFS Global компанитай гэрээтэй ажилладаг бөгөөд уг компани нь Улаанбаатар хот дахь Австралийн визний мэдүүлэг хүлээн авах төвөөр (AVAC) дамжуулан Монгол Улсын иргэдийн Австрали Улсад зорчих визний мэдүүлгийн материалыг хүлээн авах, холбогдох бусад үйлчилгээг үзүүлэх юм.

Санамж: Тус төвд хүлээн авах визний бүх мэдүүлгийг Бээжин болон Шанхай хот дахь Австралийн Цагаачлал болон хил хамгаалах алба эцэслэн шийдвэрлэнэ.

Австрали Улсын визний мэдүүлэг хүлээн авах төвийн байршил:

DHL компанийн байр, 1-р давхар
Энхтайвны өргөн чөлөө 10/5
Хороо 1, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар 14210, Монгол Улс

Утас: +976-7000 4453, +976-8688 4453
Факс: +976-7010 4410
И-мэйл: info.aumn@vfshelpline.com
Вэб хуудас: www.vfsglobal.com/australia/mongolia

Австрали Улсын визний мэдүүлэг хүлээн авах төв ажлын өдөр буюу (Даваа- Баасан) гаригт 08:00 - 15:00 цагийн хооронд иргэдийг хүлээн авч үйлчилнэ.

Даваа - Баасан гаригийн 08:00 - 15:00 цагийн хооронд иргэдэд утсаар мэдээлэл өгнө.

Тус төв дараахь үйлчилгээг үзүүлнэ:

- виз болон виз мэдүүлэхтэй холбоотой лавлагаа өгөх;
- визний бичиг баримт болон хураамж хүлээн авах;
- интернэтэд холбогдсон компьютер;
- иргэд өөрийн виз мэдүүлгийн явцыг интернэтээр шалгах системээр хангах;

- виз мэдүүлгийн хариу/паспорт/бичиг баримтийг хэrvээ байгаа бол) буцаан олгох;

Иргэд цагаачлалын албаны стандарт виз мэдүүлгийн хураамж (холбогдох бусад төлбөр) төлөхөөс гадна тус төвийн үйлчилгээний хураамж болох 70 Австрали доллар буюу 107,540 төгрөгийг төлнө.


Ихэнх виз мэдүүлгийн бичиг баримтийг электрон хэлбэрээр Хятад руу илгээх учир шуудангийн төлбөр төлөх шаардлагагүй болно. Хятад Улс дахь Цагаачлалын албаны ажилтан бичиг баримтийн цаасан эх хувийг ирүүлэхийг шаардсан тохиолдолд иргэд шуудангийн зардлыг хариуцна.

Холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар орж авна уу:
www.vfsglobal.com/australia/mongolia / www.china.embassy.gov.au / www.border.gov.au

AVAC Ulaanbaatar Map



Байршлын зураг
Location



**AUSTRALIA
VISA APPLICATION CENTER,
MONGOLIA**

**АВСТРАЛИЙН ВИЗНИЙ
МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ
ТӨВ**